

**“Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг тогтоох тухай”
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын төсөлд
саналаа өгнө үү.**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын
Усны нөөцийн хэлтэс, 51-266305

Төсөл

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2018 оны -р сарын
..... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний
хөлсийг тогтоох тухай**

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,
Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.17 дахь хэсгийг тус тус үндэслэн
ТУШААХ нь:

1. Хоногт 50 шоометр хүртэлх ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 50.000 төгрөг, 51-100 шоометр ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 100.000 төгрөг, 101-200 шоометр ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 560.000 төгрөг, 201-500 шоометр ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 645.000 төгрөг, 501-1000 шоометр ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 790.000 төгрөг, 1001-3000 шоометр ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг 845.000 төгрөгөөр, харин хоногт 3001 шоометрээс дээш ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээнээс нэг хувиар тооцож тус тус тогтоосугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/33 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ТАНИЛЦУУЛГА

“Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг тогтоох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын төсөл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.17 дахь хэсэгт “ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан байдаг.

2016 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай” А/33 дугаар тушаалаар “ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс”-ийг шинэчлэн баталж, уг тушаалыг Хууль зүйн яамны улсын нэгдсэн бүртгэлийн 3421 дугаарт /нэмэлт өөрчлөлт-1/ бүртгүүлсэн.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд “Монгол-Ус” ТӨААТҮГ, Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гарган өгч байгаа бөгөөд дүгнэлт гаргасны үйлчилгээний хөлсийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/33 дугаар тушаалын дагуу тооцон авч байна.

Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлстэй холбоотойгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/33 дугаар тушаалд өөрчлөлт оруулах хүсэлт, саналуудыг ирүүлсэн.

Ирүүлсэн мэдээ, хүсэлт, саналын дагуу холбогдох тооцоо, судалгааг хийж “Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг тогтоох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын төслийг боловсрууллаа.

“Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг тогтоох тухай” тушаалыг баталснаар Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

**Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын
Усны нөөцийн хэлтэс**